



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 4/52

Улаанбаатар хот

Журам, жагсаалтыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.2, 17.1.3, 17.1.4, 17.1.5, 17.1.6, 17.1.7, 17.2, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сум, тосгоны эрүүл мэндийн төвд тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг нэгдүгээр, Сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Бодлого төлөвлөлтийн газар /Р.Оюунханд/, Эмнэлгийн тусламжийн газар /М.Баттүвшин/, Нийгмийн эрүүл мэндийн газар /Т.Энхзаяа/ -т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар /Я.Амаржаргал/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 246 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2019 оны
02 дугаар сарын 04-ний өдрийн
А/52 тушаалын нэгдүгээр хавсралт

СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь хүн амд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг өрхийн анагаах ухаанд суурилан чанартай, тэгш, хүртээмжтэй, тасралтгүй, цогц байдлаар үзүүлэхэд оршино.
- 1.2 Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 1.3 Уг журмыг сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд мөрдөн ажиллана.
- 1.4 Сум, тосгоны эрүүл мэндийн төвийг цаашид "Төв" гэнэ.

Хоёр. Тусламж, үйлчилгээний үндсэн зарчим

- 2.1 Үйлчлүүлэгчийн эрхийг дээдэлсэн, тэдний эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх;
- 2.2 Иргэд, олон нийтийн оролцоо, дэмжлэгт орчныг хангасан, сонголтыг хүндэтгэсэн "Хүн төвтэй цогц тусламж, үйлчилгээ"-г үзүүлэх;
- 2.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь нотолгоонд тулгуурласан байх;
- 2.4 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгох;
- 2.5 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд бүх нийтийг хамруулан, хэнийг ч орхигдуулахгүй байх;
- 2.6 Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээг иргэн бүрт жигд, хүртээмжтэй, чанартай, чирэгдэлгүй үзүүлэх;
- 2.7 Эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэх, шилжүүлэх, эргэх холбоо тогтоох зэргээр тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах.

Гурав. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний ерөнхий зохицуулалт

- 3.1 Төв нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эмнэлгийн анхан шатлалын тусламжийг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, дэмжих үйлчилгээний хэсгээс бүрдсэн зохион байгуулалттай байна.
- 3.2 Төв нь Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын шаардлага, тусгай зөвшөөрөлд үндэслэн энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтад заасан тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

- 3.3 Төв нь тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүүжилт, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.
- 3.4 Төв нь цахим бүртгэл, төрийн нэгдсэн цахим сүлжээнд холбогдох, зайн оношилгоог ашиглан тусламж, үйлчилгээг үзүүлэх нөхцлийг бүрэн хангасан байна.
- 3.5 Төв нь тусламж, үйлчилгээний холбогдох эмнэлзүйн заавар, журам, стандартыг эмч, эмнэлгийн мэргэжилтнийг судлах нөхцлийг хангаж, мөрдүүлэн ажиллана.
- 3.6 Төвийн эмнэлгийн мэргэжилтэн, ажилтныг эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, харилцаа, хандлагын алдаа гаргахаас сэргийлж, удирдлагын арга зүйгээр хангаж ажиллана.
- 3.7 Төв нь нутаг дэвсгэрийн нийт хүн амын бүртгэл судалгааг жил бүр шинэчлэн, иргэнийг эрүүл мэндийн 5 бүлгээр, өрхийг эрүүл мэндийн эрсдэлийн 3 бүлгээр тус тус ангилан, хяналт тогтоож, эрэлт хэрэгцээнд нь тохирсон тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 3.8 Нутгийн захиргааны байгууллагын дэмжлэг, бусад салбарын байгууллага, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Дөрөв. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

- 4.1 Хүн амын эрүүл мэндийн байдалд тандалт, өвчлөлийн байдалд дүн шинжилгээ хийж, эрэлт хэрэгцээг тодорхойлно.
- 4.2 Халдварт өвчин гарахад нөлөөлөх хүрээлэн буй орчны болон халдварт бус өвчний нийгмийн хүчин зүйлийн эрсдэлийг илрүүлэх, түүнийг таслан зогсоох арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 4.3 Хүн амыг ундны усаар хангах, төвлөрсөн бус ариун цэврийн байгууламж болон улсын чанартай авто замын дагуу зориулалтын ариун цэврийн байгууламж, хог хаях цэг байгуулах асуудлаар Засаг даргад санал тавьж шийдвэрлүүлнэ.
- 4.4 Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, жирэмснээс сэргийлэх чиглэлээрх арга хэмжээг зохион байгуулна.
- 4.5 Халдварт өвчний тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, голомтын болон хариу арга хэмжээг шуурхай авч, тандах, хянах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 4.6 Халдварт өвчний эсрэг заавал хийх, нөхөн, нэмэлт, тархвар судлалын заалтаар болон сайн дурын дархлаажуулах ажлыг зохион байгуулна.
- 4.7 Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвар, томуу, томуу төст өвчин, зоонозын шалтгаант өвчний хариу арга хэмжээг хангах, халдварт өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэх, тандах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 4.8 Эрүүл мэндийн байгууллагын халдварын сэргийлэлт, хяналт, эмнэлгийн болон бусад халдвартай хог хаягдлыг байгаль орчинд аюулгүйгээр зайлуулан устгах, түүний хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллана.
- 4.9 Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал, байгалийн гамшиг, осол, химийн хортой бодис, угаарын хордлого, олон хүний амь насанд аюул учруулах халдварт өвчний үед хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нөөцийн бэлэн

байдал, хариу арга хэмжээг шуурхай авах нөхцлийг хангаж, бусад байгууллагыг мэргэжлийн арга зүйгээр хангана.

4.10 Орон нутгийн хүн амын нас, зорилтот бүлэг тус бүрийн онцлогт тохирсон, эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн мэдлэг олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг олон нийтийг татан оролцуулах, сайн дурын идэвхтнийг бэлтгэх зэргээр тасралтгүй зохион байгуулна.

4.11 Сэтгэцийн эрүүл мэнд, гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгааг иргэдийн дунд явуулан, хүчирхийлэлд өртөгсдийг илрүүлж, зөвлөгөө өгнө.

4.12 Эрүүл чанартай урт наслах, настны сэтгэцийн эрүүл мэнд, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

4.13 Уламжлалт анагаах ухааны аргаар хүн амын ёс заншил, зан үйл, идээ ундаа, явдал мөртэй уялдуулан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

4.14 Зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний эрсдэлийг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулж, өвчнийг эрт үед нь илрүүлэн, хянана.

4.15 Сургууль, цэцэрлэгийн эмч нарыг мэргэжлийн арга зүйгээр хангаж, хүүхдийн өсөлт, хөгжилтийг үнэлэх, биеийн жингийн индексийг тодорхойлох болон амны хөндий, шүд, гүйлсэн булчирхай, харааны эмгэгийг илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгийг жил бүр хамтран зохион байгуулж, эрүүлжүүлэлтэд хяналт тавьж ажиллана.

4.16 Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд иргэн, олон нийт, эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн, аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулах, орон нутгийн удирдлага, албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга нарт нөлөөллийн ажлыг зохион байгуулан мэргэжлийн арга зүйгээр хангана.

4.17 Нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан байгууллага, аж ахуйн нэгжийн ажиллагсдын дунд урьдчилан сэргийлэх үзлэгийг тухайн байгууллагатай хамтран зохион байгуулна.

Тав. Эмнэлгийн анхан шатлалын тусламж, үйлчилгээ

5.1 Иргэнд хүний амьдралын бүхий л мөчлөг, насны онцлогт тохирсон оношлох, эмчлэх, сэргээн засах, сувилах, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг цогцоор тасралтгүй үзүүлнэ.

5.2 Сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс иргэнийг эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт илгээх журмыг баримтлан цахимаар цаг товлон, эргэх холбоо тогтоох үйлчилгээг нэвтрүүлэн, хэрэгжүүлнэ.

5.3 Жирэмсэн болон төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журам, Нярайд зонхилон тохиолдох өвчний заавар, Хүүхдийн өвчний цогц менежментийг мөрдөж ажиллана.

- 5.4 Зарим сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо шинжилгээг даатгалын санхүүжилтээр үзүүлэх сонгон шалгаруулалтад орж, гэрээ байгуулж ажиллана.
- 5.5 Сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээг үзүүлэхдээ Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан Сэргээн засах тусламж, үйлчилгээний журам, Гэрээр сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх журам, Өдрийн эмчилгээ, үйлчилгээний журмыг тус тус мөрдөж ажиллана.
- 5.6 Эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээний холбогдох заавар, журмын хүрээнд өөрийн байгууллагын тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэх дотоод журмыг баталж хэрэгжүүлэн ажиллана.
- 5.7 Төв нь яаралтай тусламжийн нэгжтэй байх ба эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг яаралтай тусламжийн чиглэлээр сургаж, дадлагажуулсан байна.
- 5.8 Эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээг иргэний бүртгэл, харъяалал харгалзахгүйгээр үзүүлж, шаардлагатай бол дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагад шилжүүлнэ.
- 5.9 Шаардлагатай тохиолдолд нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн яаралтай тусламжийн багийг дуудаж, газар дээр нь тусламж, үйлчилгээг үзүүлэх нөхцлийг хангаж, хамтран ажиллана.
- 5.10 Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд оношлох, эмчлэх, сэргээн засах, сувилах, хөнгөвчлөх, лавлагаа шатлалд илгээх, хянах тусламж, үйлчилгээг холбогдох журам, зааврын дагуу тасралтгүй үзүүлнэ.
- 5.11 Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг эмийн болон заслын хэлбэрээр үзүүлнэ.
- 5.12 Төв нь нийт хүн амынхаа нэг хувьтай тэнцэх цусны донорыг элсүүлэн бэлтгэж, тогтмол шинжилгээнд хамруулж, эрүүл, аюулгүй цусны бэлэн байдлыг хангана.
- 5.13 Сум дундын эмнэлэг нь дотор, хүүхэд, эх барих, мэс засал, шүдний мэргэшлийн эмчийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 5.14 Төв нь явуулын тусламж, үйлчилгээг алслагдсан газар нутагт амьдарч байгаа иргэд болон отор нүүдэл хийж буй малчдад очиж үзүүлнэ.
- 5.15 Цахим эрүүл мэндийн технологийг нэвтрүүлэн, амбулаторийн болон явуулын тусламж үйлчилгээнд ашиглана.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны
02 дугаар сарын 04 ний өдрийн
тушаалын хоёрдугаар хавсралт

4/52



**СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВДҮЗҮҮЛЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ**

1.НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

1.1 Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах	
1.1.1	Хүн амын бүртгэл, мэдээллийг жил бүр шинэчлэн хөтлөх
1.1.2	Иргэний эрүүл мэндийн бүлэг, өрхийн эрүүл мэндийн эрсдэлийн бүлэгт жил бүр үнэлгээ, дүгнэлт хийж, хяналт тогтоох, цаашид авах арга хэмжээг төлөвлөх
1.1.3	Иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх халдварт өвчний хүчин зүйлийн тандалт хийх
1.1.4	Халдварт бус өвчин үүсэхэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийн тандалт хийх
1.1.5	Хүн амын өвчлөлийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, эрэлт хэрэгцээг тодорхойлох
1.2 Эрүүл мэндийг дэмжих	
1.2.1	<p><i>Эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх чиглэлээр:</i></p> <ul style="list-style-type: none"> - Албан байгууллага, аж ахуйн нэгжийг эрүүл мэндийг дэмжигч байгууллага болоход мэргэжлийн арга зүйгээр хангах - “Эрүүл мэндийг дэмжигч өрх”, “Эрүүл мэндийг дэмжигч хамт олон”, “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” шалгаруулах аян зохион байгуулах - Аж ахуйн нэгж, албан байгууллагуудад тамхигүй орчин бий болгох, архины зохистой хэрэглээг сурталчлахад дэмжлэг үзүүлэх
1.2.2	<p><i>Олон нийт, нийгмийн оролцоог эрчимжүүлэх чиглэлээр:</i></p> <ul style="list-style-type: none"> - Орон нутгийн болон албан байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад нөлөөллийн ажлыг зохион байгуулах - Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд иргэд, олон нийт, эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн, аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулах - Эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах / ЗГ-ын 2001 оны 224 дүгээр тогтоол/
1.2.3	<p><i>Хувь хүний чадварыг хөгжүүлэх чиглэлээр:</i></p> <ul style="list-style-type: none"> - Цэцэрлэг, сургууль, орон гэр, ажлын байр, албан байгууллага хамт олныг түшиглэн эрүүл мэндийн боловсрол олгох, зөвлөгөө өгөх хэлбэрээр сайн дурын байгууллага, нэгжээр дамжуулан мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх. <p>Эрүүл, зөв зохистой хооллолтыг дэмжих</p> <ul style="list-style-type: none"> - Буруу хооллолтын хандлага, дадлыг илрүүлэх - Хоол хүнсний чанарыг алдагдуулахгүй бэлтгэх, боловсруулах,

	<p>хадгалах</p> <ul style="list-style-type: none"> - хэрэглэхийг зөвлөх - Өдөр тутмын хоол хүнсний бүтээгдэхүүний зохистой харьцаа, зөв сонголт 																
	<p>Дасгал хөдөлгөөн, чийрэгжүүлэлтийг дэмжих</p> <ul style="list-style-type: none"> - Хүн бүр өдөрт наад зах нь 30 минут шаламгай алхах, идэвхтэй хөдөлгөөн хийхийг уриалах, өөрсдөө үлгэрлэх - Хүүхэд, залуучууд биеийн тамир, чийрэгжүүлэх дасгалыг долоо хоногт 3 удаа, 60 минутаас доошгүй хугацаагаар хийх боломжийг хангаж ажиллахыг сургууль цэцэрлэгийн удирдлагуудад уриалж, хамтран ажиллах - Хүн амд биеийн жингээ тогтмол хэмжээнд барихын тулд өдөрт наад зах нь 1 цаг хүч тэнхээ шаардсан биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр хичээллэхийг уриалах, сурталчлах 																
<i>Зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн боловсрол олгох:</i>																	
	<table> <tr> <th>Зорилтот бүлэг</th><th>Агуулга</th></tr> <tr> <td>1.2.3.1</td><td>Жирэмсэн болон төрсөн эмэгтэй</td></tr> <tr> <td>1.2.3.1</td><td>Эцэг, эх, асран хамгаалагч</td></tr> <tr> <td>1.2.3.2</td><td>Бага насны хүүхэд</td></tr> <tr> <td>1.2.3.3</td><td>Өсвөр үеийн хүүхэд</td></tr> <tr> <td>1.2.3.4</td><td>Архаг өвчтэй хүмүүс</td></tr> <tr> <td>1.2.3.5</td><td>Ахмад настан</td></tr> <tr> <td>1.2.3.6</td><td>Хөгжлийн</td></tr> </table>	Зорилтот бүлэг	Агуулга	1.2.3.1	Жирэмсэн болон төрсөн эмэгтэй	1.2.3.1	Эцэг, эх, асран хамгаалагч	1.2.3.2	Бага насны хүүхэд	1.2.3.3	Өсвөр үеийн хүүхэд	1.2.3.4	Архаг өвчтэй хүмүүс	1.2.3.5	Ахмад настан	1.2.3.6	Хөгжлийн
Зорилтот бүлэг	Агуулга																
1.2.3.1	Жирэмсэн болон төрсөн эмэгтэй																
1.2.3.1	Эцэг, эх, асран хамгаалагч																
1.2.3.2	Бага насны хүүхэд																
1.2.3.3	Өсвөр үеийн хүүхэд																
1.2.3.4	Архаг өвчтэй хүмүүс																
1.2.3.5	Ахмад настан																
1.2.3.6	Хөгжлийн																
1.2.3.1	<p>Хооллолт, хүнс тэжээл, жирэмсний эрүүл ахуй, жирэмсэнтэй холбоотой бусад сэдвүүд, нярайн асаргаа, хүүхдийн өсөлт, бойжилтыг үнэлэх, төрөлт хоорондын зайг зохицуулах, сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэл гутрал, гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх</p>																
1.2.3.1	<p>Гэр бүл төлөвлөлт, жирэмснээс хамгаалах эм, хэрэгсэл, 0-5 насны эрүүл болон өвчтэй хүүхдийн асаргаа сувилгаа, хооллолт, хүүхдийн осол гэмтлээс сэргийлэх, автомашинд хүүхдийн суудлыг хэрэглэж занших, хүүхдийг ахуйн гэмтэл, түлэгдлээс сэргийлэх, аюултай шинж илэрсэн үед тусламж хайх чадвартай байх</p>																
1.2.3.2	<p>Гараа зөв угаах, зөв хооллох, шүдээ зөв угаах дадал, дасгал хөдөлгөөн, осол, гэмтэл, түлэгдэлт, автомашины суудалд зөв суух, дулаан хувцаслах, ханиад томууны үед амны хаалт зүүх тухай</p>																
1.2.3.3	<p>Хооллолт, дасгал хөдөлгөөн, архи, тамхи, мансууруулах бодисоос татгалзах, биений юмны эрүүл ахуй, нөхөн үржихүйн эрүүл мэнд, БЗДХ/ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх, бэлгийн чиг хандлага, сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэл гутрал, амиа хорлохоос сэргийлэх, бэлгийн хүчирхийлэл, цахим орчны зөв хэрэглээ</p>																
1.2.3.4	<p>Хооллолт, дасгал хөдөлгөөн, эмчилгээг зааврын дагуу хийх, сэтгэцийн эрүүл мэнд, хорт зуршлаас сэргийлэх, тухайн өвчний онцлогтой холбоотой баримтлах дэглэмийн тухай</p>																
1.2.3.5	<p>Хооллолт, дасгал хөдөлгөөн, эрүүл насжих, хөгшрөлтийн тухай, унахаас сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэнд, эмэгтэйчүүдэд-цэвэршилтийн дараах үеийн асуудал, ясны сийрэгжилт</p>																
1.2.3.6	<p>Хооллолт, дасгал хөдөлгөөн, сэргээн засах үйл</p>																

	бэрхшээлтэй хүн	ажиллагаанд идэвхтэй оролцох, шийдвэр гаргах, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө
1.2.3.7	Насанд хүрэгч	Зонхилон тохиолдох халдварт өвчнөөс сэргийлэх, сайн дурын шинжилгээ, зөвлөгөөний тухай /БЗДХ/ХДХВ/ДОХ, сүрьеэ/
1.2.3.8		Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх, эрт илрүүлэг, хөдөлгөөний хомсдол, таргалалт, хавдар, осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх
1.2.3.9	Малчид	Мал, амьтнаас хүнд халдварладаг бруцеллёз, тарваган тахал, боом, галзуу, бэтэг, хачигт халдвар зэрэг өвчнөөс сэргийлэх, мотоцикль унах үед хамгаалалтын малгай өмсөж хэвших, мотоциклээс унахаас сэргийлэх, амьдралын зөв дадал хэвшүүлэх, архи, тамхины хор уршиг
1.2.3.10	Амьдралын буруу хэв маягийг өөрчлөх, зан үйлийн эрсдэлтэй, мансууруулах бодисын хамааралтай хүн	Хооллолт, дасгал хөдөлгөөн, сэтгэцийн эрүүл мэнд, донтолт, хорт зуршлаас татгалзах, тамхинаас гарах зөвлөгөө өгөх, архины донтолтод дэмжлэг үзүүлэх, шилжүүлэх.
1.2.3.11	Байгууллага, хамт олон	Эрүүл ажлын байр, ажлын байрны дасгал, ажлын байрны дарамт, урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэгт орохын ач холбогдол, ажил, амралтаа зохицуулах, архины стандарт хэрэглээ, тамхинаас гарахад туслах, эрхэлж буй ажлын эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлт байдалтай холбоотой сэдэв

1.3. Эрүүл мэндийг хамгаалах

1.3.1.	Урьдчилан сэргийлэх үзлэг
	<ul style="list-style-type: none"> - Хүн амыг насны ангиллаар жил бүр үзлэгт оруулах, эрүүл мэндийн бүлгийг тодорхойлох, /Эрүүл мэндийн 1-5-р бүлэг / - Нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан байгууллага, аж ахуйн нэгжийн ажиллагсдын дунд урьдчилан сэргийлэх үзлэгийг тухайн байгууллагатай хамтран зохион байгуулах
1.3.2	Эрт илрүүлэг /Тухайн үед мөрдөгдөж байгаа журам, заавар, удирдамжийг мөрдөнө/
1.3.2.1	<u>Артерийн даралт ихсэлтийн эрт илрүүлэг</u> <ul style="list-style-type: none"> - 18-34 насны хүн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэгт ороход артерийн гипертензийн илрүүлэг хийх - 40-өөс дээш насны хүн бүрийг жилд 1 удаа илрүүлэгт хамруулах - Хооллолт, дасгал хийх, амьдралын хэв маягийг өөрчлөх зөвлөгөө өгөх - Эмнэлзүйн зааврын дагуу эмчилгээ хийх, хянах - Хүндрэлийг эрт тодорхойлох - Шаардлагатай бол лавлагаа шатлал руу шилжүүлэх - Эргэх холбоо тогтоож, үргэлжлүүлэн хянах

1.3.2.2	<p><u>Чихрийн шижингийн эрт илрүүлэг</u></p> <ul style="list-style-type: none"> - 35-65 насны хүн бүрийг жилд 1 удаа чихрийн шижингийн илрүүлэгт хамруулах - Цусан дахь сахарын хэмжээг үнэлж, оношийг баталгаажуулах - Амьдралын хэв маягийг өөрчлөх, хооллолт, дасгал, хөлийн арчилгааны талаар зөвлөгөө өгөх - Гликемитэй хүмүүсийн биеийн байдлыг тогтмол хянаж, үнэлэх, эмчилгээнд оруулж, үзүүлэлтийг хүссэн хэмжээнд хүргэх, тогтворжуулах, - Жирэмсний чихрийн шижинтэй байсан түүхтэй эмэгтэйчүүдийг хянах - Чихрийн шижин төст невропати, ретринопатийн хүндрэлтэй бүх өвчтөнд удирдамжийн дагуу илрүүлэг хийх - Хүндрэлийг эрт тодорхойлж, шаардлагатай бол лавлагаа шатлал руу шилжүүлэх
1.3.2.3	<p><u>Зүрхний архаг дутагдлын эрт илрүүлэг</u></p> <ul style="list-style-type: none"> - ЗАД-ын эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлох - 35-аас дээш насны эрт илрүүлэгт хамрагдах хүмүүсийг сонгох <ul style="list-style-type: none"> • 35-44 насны эрэгтэйчүүдийг 4 жил, эмэгтэйчүүдийг 5 жил, • 45-54 насны эрэгтэйчүүдийг 2-3 жил, эмэгтэйчүүдийг 3-4 жил тутамд, • 55-64 насны эрэгтэйчүүдийг жил бүр, эмэгтэйчүүдийг 2 жил тутамд эрт илрүүлгийн үзлэгт хамруулах, - Эмнэлзүйн зааврын дагуу эмчилгээ хийх, хяналт тавих - Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт заалтын дагуу илгээх - Хөдөлгөөний зохистой дэглэм, эрүүл хооллолт, шингэний хэрэглээний зохицуулалт, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах талаар эрүүл мэндийн боловсрол олгох, зөвлөгөө өгөх
1.3.2.4	<p><u>Дислипидемийн эрт илрүүлэг</u></p> <ul style="list-style-type: none"> - Эрт илрүүлэгт хамрагдах зорилтот бүлгийн хүмүүсийг сонгох <ul style="list-style-type: none"> • 35 ба түүнээс дээш насны бүх эрэгтэйчүүд • 45 ба түүнээс дээш насны бүх эмэгтэйчүүд • ЗСАӨ-ний эрсдэлтэй 21-34 насны эрэгтэйчүүд • ЗСАӨ-ний эрсдэлтэй 21-44 насны эмэгтэйчүүдийг • Удмын гиперхолестеролемийн эрсдэлтэй хүүхдэд 3 настайгаас эхэлж, 9-11, 18 настайд давтан хийх - Эрт илрүүлгийн өмнөх зөвлөгөө өгөх - Эрт илрүүлэгт хамрагдсан эсэхэд хяналт тавих - ЗСАӨ-ний 10 жилийн эрсдлийг үнэлэх - Эмчилгээний хяналт
1.3.2.5	<p><u>Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг</u></p> <ul style="list-style-type: none"> - 30-60 насны эмэгтэйчүүдийг 3 жилийн давтамжтайгаар илрүүлэгт хамруулах - Умайн хүзүүний сувгаас эсийн шинжилгээ авч, илгээх - Шинжилгээний хариуг авч үйлчлүүлэгчид өгөх - Зөвлөгөө өгөх - Сэжигтэй илрэгсдийг онош баталгаажуулах шинжилгээнд илгээх - Эмчилгээний үр дүнд хяналт тавих

1.3.2.6	<p><u>Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг</u></p> <ul style="list-style-type: none"> - 30-60 насны эмэгтэйчүүдийг умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт ирэх үед хөхний үзлэгийг хийх - Хөхний хавдрын эрсдэл өндөртэй эмэгтэйчүүдийг 25-30 наснаас эхэлж маммограмын шинжилгээнд хамрагдахыг зөвлөх - Маммограмын шинжилгээнд хамрагдсан эсэхэд хяналт тавих - 18 –аас дээш насны эмэгтэйчүүдэд хөхөө өөрөө шалгахын ач холбогдлыг таниулах, хөхөө хэрхэн шалгах аргад сургах - Эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн үзлэг хийх бүрт хөхний үзлэгийг давхар хийх - Сэжигтэй тохиолдлыг дараагийн шатлалын эмнэлэгт илгээх - Эмчилгээний үр дүнд хяналт тавих
1.3.2.7	<p><u>Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг</u></p> <ul style="list-style-type: none"> - Эрт илрүүлэгт хамруулах зорилтот бүлгийн хүн ам: <ul style="list-style-type: none"> • HBsAg, Anti-HCV эерэг B,C вируст гепатитын халдвар тээгчид; • вируст гепатитын B,C вирусын халдвар тээгч гэдгээ өмнө нь мэддэг бүх насны хүмүүс • 40-65 насны HBsAg, Anti-HCV илрүүлэх шинжилгээнд хамрагдан гепатитын B,C вирус тээгч болох нь батлагдсан хүмүүс • 50-иас дээш насны, Anti-HCV эерэг C вируст гепатитын халдвартай, элэгний хатуурал хавсарсан хүмүүс • Элэгний архаг үрэвсэлтэй (ALAT 60-аас дээш), элэгний хатууралтай бүх насны хүмүүс • Элэгний анхдагч хорт хавдраар өвчлөгсдийн нэгдүгээр үеийн төрөл садан ба гэр бүлийн 40 –өөс дээш насны хүмүүс - Зорилтот бүлгийн хүн амыг үзлэгийн хуваарийн дагуу 6 сар, 12 сар тутамд эрт илрүүлгийн үзлэгт бүрэн хамруулах - Шинжилгээнд илгээх - Эргэх холбоо тогтоож, хяналт тавих
1.3.2.8	<p><u>Улаан хоолойн хорт хавдрын эрт илрүүлэг</u></p> <ul style="list-style-type: none"> - Зорилтот бүлгийн хүн амын бүртгэл, үзлэгийн хуваарь хийх - Зорилтот бүлгээр сонгогдсон хүн амыг үзлэгт илгээх - 40 - өөс дээш насны бүх хүнийг улаан хоолой, ходоодны дурангийн шинжилгээнд илгээх - Дурангийн шинжилгээ хийлгэсэн эсэхэд хяналт тавих - Улаан хоолойн хавдар илэрсэн хүнд лавлагаа шатлалын эмчийн зөвлөмжийн дагуу тусламж, үйлчилгээ үзүүлэх
1.3.2.9	<p><u>Ходоодны хорт хавдрын эрт илрүүлэг</u></p> <ul style="list-style-type: none"> - Зорилтот бүлгийн хүн амын бүртгэл, үзлэгийн хуваарь хийх - Зорилтот бүлгээр сонгогдсон хүн амыг үзлэгт илгээх - 40 - өөс дээш насны бүх хүнийг хеликобактер илрүүлэх шинжилгээ болон улаан хоолой, ходоодны дурангийн шинжилгээнд илгээх - Хеликобактер илэрсэн тохиолдолд эмчлэх, хяналт тавих - Дурангийн шинжилгээ хийлгэсэн эсэхэд хяналт тавих - Ходоодны хавдар илэрсэн хүнд лавлагаа шатлалын эмчийн зөвлөмжийн дагуу тусламж, үйлчилгээ үзүүлэх

1.3.2.10	<p><u>Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэг</u></p> <ul style="list-style-type: none"> - 50 –иас дээш насны хүнийг 5 жил тутамд 1 удаа эрт илрүүлэгт хамруулах - Эрсдэлт хүн ам: <ul style="list-style-type: none"> • Гэр бүлд бүдүүн гэдэсний хорт хавдраар өвдөж байсан түүхтэй • Гэдэсний ямар нэгэн үрэвсэлт өвчнөөр өвдөж байсан (гэр бүлийн өвчний түүхэнд өвчилсөн хүн байсан) бол 45 наснаас дээш 10 жилд 1 удаа бүдүүн гэдэсний дуран хийлгэх • Хэвлийн хэсгээр туяа эмчилгээнд орж байсан. - Шулуун гэдэсний дурангийн шинжилгээ хийлгэхийг зөвлөх, илгээх - Дурангийн шинжилгээ хийлгэсэн эсэхийг хянах - Эргэх холбоо тогтоож, хяналт тавих
----------	---

ХОЁР. ЭМНЭЛГИЙН АНХАН ШАТЛАЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

2.1. Жирэмсэн, төрсний дараах үеийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

Зорилтот бүлэг	Тусламж үйлчилгээний жагсаалт	Тусламж, үйлчилгээний хэлбэр				
		Урьдчилан сэргийлэх	Амбулаторийн үзлэг, оношилгоо	Хэвтүүлэн эмчлэх	Хяналт тавих	Лавлагаа шатлалд илгээх
Жирэмсэн үеийн тусламж, үйлчилгээ	Эрүүл жирэмсний хяналт	√	√		√	√
	Эрсдэлтэй жирэмсний хяналт	√	√	√	√	√
	Жирэмсний цус багадалт	√	√		√	√
	Илүү тээлт	√	√	√	√	√
	Зулбалт, дутуу төрөхийг завдах	√	√	√	√	√
	Жирэмсний эрт ба хожуу үеийн цус алдалт	√	√	√	√	√
	Манас таталт, манас таталтын урьдал	√	√	√	√	√
	Жирэмсэн үеийн бусад эмгэгүүд	√	√	√	√	√
Төрсний дараах тусламж, үйлчилгээ	Эхийн гэрийн эргэлт, хяналт	√			√	
	Төрсний дараах үеийн халдварын хяналт, тусламж, үйлчилгээ	√		√	√	√
	Төрсний дараах үеийн цус	√		√	√	√

	алдалт					
	Төрсний дараах үеийн манас таталт	√		√	√	√
	Төрсний дараах үеийн хөхний үрэвсэл	√		√	√	√
	Төрсний дараах үеийн сэтгэл гутрал	√		√	√	√
Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээ	Гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээ /Жирэмснээс сэргийлэх эм, хэрэгслийн хэрэглээ/	√	√		√	√
	Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэг	√	√			
	Эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчин	√	√		√	√
	Үтрээнээс цус алдах хам шинж	√	√		√	√
	Цэвэршилтийн үеийн тусламж үйлчилгээ	√	√		√	√
	Умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх	+	+		+	
	Хөхний хорт хавдрыг эрт илрүүлэх	+	+		+	
	Эмэгтэйчүүдийн бусад өвчин эмгэг	+	+		+	

2.2. Хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ

Зорилтот бүлэг	Тусламж, үйлчилгээний жагсаалт	Тусламж, үйлчилгээний хэлбэр					
		Урьдчилан сэргийлэх	Амбулаторийн үзлэг, оношилгоо, эмчилгээ	Хэвтүүлэн эмчлэх	Гэрийн эмчилгээ	Хяналт тавах	Лавлагаа шатлалд илгээх
Эрүүл нярай	Гэрээр эргэх	√				√	
	Нярайн асаргаа, сувилгаа, зөвлөгөө өгөх	√				√	
	Товлолт дархлаажуулалтанд хамруулах	√				√	
	Өсөлт, хөгжлийг үнэлэх	√	√	√		√	
Өвчтэй	Шарлалттай нярайд үзүүлэх	√	√	√		√	√

нярай	тусламж, үйлчилгээ						
	Хооллолтын бэрхшээлтэй, бага жинтэй нярайд үзүүлэх тусламж	√	√	√		√	√
	Суулгалттай нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээ	√	√	√	√	√	
	Арьсны идээт тууралттай, нянгийн халдвартай нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээ	√	√	√	√	√	√
	Хатгаатай нярайд үзүүлэх тусламж	√	√	√		√	
	Аюултай болон тулгамдсан шинж илэрсэн нярайд үзүүлэх тусламж		√	√	√		√
	Нярайн төрөлхийн хөгжлийн гажгийг илрүүлэх	√	√			√	√
	Гэрээр эргэх	√				√	
5 хүртэлх насны эрүүл хүүхэд	Хүүхдийн асаргаа, сувилгаа, зөвлөгөө өгөх	√				√	
	Аминдэмийг сэргийлэх тунгаар өгөх	√				√	
	Хооллолтыг үнэлэх	√	√	√		√	
	Заавал хийх болон нөхөн дархлаажуулалтанд хамруулах	√				√	
	Өсөлт, хөгжлийг үнэлэх	√	√	√		√	
	Нэмэлт дархлаажуулалтанд хамруулах	√	√	√			
	Тархвар судлалын заалтаар дархлаажуулалт хийх	√	√	√			
	Төрөлхийн хөгжлийн гажгийг илрүүлэх	√	√	√		√	
	Хараа шалгах	√	√	√			
	Амны хөндийн үзлэг хийх	√	√	√			
5 хүртэлх насны өвчтэй хүүхэд	Аюултай ерөнхий шинжтэй хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ		√	√	√	√	√
	Ханиалгалт ба амьсгал саадтай үед үзүүлэх тусламж, үйлчилгээ		√	√	√	√	
	Суулгалтын үед үзүүлэх тусламж, үйлчилгээ		√	√	√	√	
	Халууралтын үед үзүүлэх тусламж, үйлчилгээ		√	√	√	√	
	Чихний өвчний үед үзүүлэх тусламж, үйлчилгээ		√	√	√	√	

	Суурь өвчтэй хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ	√	√	√	√	√	
	Хооллолтын бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ	√	√	√	√	√	
	Бусад эрхтэн тогтолцооны эмгэгтэй хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ	√	√	√	√	√	√
Өсвөр насны хүүхэд	Сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ	√	√	√		√	
	Хараа шалгах	√	√			√	√
	Амны хөндийн үзлэг	√	√			√	√
	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	√	√	√		√	
	БЗДХ/ХДХВ/ДОХ-ийн тусламж, үйлчилгээ	√	√	√		√	√
	Хорт зуршлаас сэргийлэх, эрт илрүүлэлтийн үеийн тусламж, үйлчилгээ	√	√	√		√	
	Нэмэлт дархлаажуулалтанд хамруулах	√	√			√	
	Тархвар судлалын заалтаар дархлаажуулалт хийх	√	√				

2.3. Дархлаажуулалтын тусламж, үйлчилгээ

	Дархлаажуулалтын төрөл	Амбулаторийн тусламж, үйлчилгээ
1.3.1	Заавал хийх дархлаажуулалт	√
1.3.2	Нөхөн дархлаажуулалт	√
1.3.3	Нэмэлт дархлаажуулалт	√
1.3.4	Тархвар судлалын заалтаар хийх дархлаажуулалт	√

2.4. Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээ

Зорилтот бүлэг	Тусламж үйлчилгээний жагсаалт	Тусламж, үйлчилгээний хэлбэр					
		Амбулаторийн үзлэг, оношилгоо	Хэвтүүлэн эмчлэх	Гэрийн эмчилгээ	Өдрийн эмчилгээ	Хяналт тавих	Лавлагаа шатлалд илгээх
	Настны эрүүл мэндийн эрсдэлийг илрүүлэх, үнэлэх	√				√	

Ахмад настан	Хараа шалгах	√				√	√
	Сонсгол шалгах	√				√	√
	Үе, мөчний эмгэгийг илрүүлэх, эмчлэх	√	√		√	√	√
	Хэвтрийн болон хөгжлийн бэрхшээлтэй ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээ	√	√	√	√	√	√
	Ахмад настны сувилахуйн тусламж, үйлчилгээ	√	√	√	√	√	
	Сэргээх засах тусламж, үйлчилгээ	√	√	√	√	√	
	Нийгмийн халамж шаардлагатай ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээ	√					

2.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх тусламж үйлчилгээ

Зорилтот бүлэг	Тусламж үйлчилгээний жагсаалт	Тусламж, үйлчилгээний хэлбэр					
		Амбулаторийн үзлэг, оношилгоо	Хэвтүүлэн эмчлэх	Гэрийн эмчилгээ	Өдрийн эмчилгээ	Хяналт тавих	Лавлагаа шаталд илгээх
Хөгжлийн бэрхшээлтэй хүн	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээнд тулгуурласан тусламж, үйлчилгээ	√	√	√	√	√	√
	Хөгжлийн бэрхшээлийн хүнд болон түүний гэр бүлийн гишүүдэд гэрийн нөхцөлд хийх сэргээн засалтын дасгал хөдөлгөөнийг зааж өгөх			√		√	
	Анхдагч, хоёрдогч хүндрэлд орохоос урьдчилан сэргийлэх	√	√	√	√	√	
	Дасгал хийж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тогтмол хянах, ахиц дэвшлийг үнэлэх			√	√	√	
	Хэрэгцээтэй тусламж, үйлчилгээнд зуучлах /лавлагаа шат, сувилал, сэргээн засалтын төв/	√					√
	Хөгжлийн бэрхшээлийн хүндрэлээс урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн сургалт	√	√	√			
	Нийгмийн халамжид хамруулах	√			√		

2.6. Халдварт бус өвчний үеийн тусламж, үйлчилгээ

Өвчний бүлэг	Тусламж, үйлчилгээ үзүүлэх өвчний жагсаалт	Тусламж, үйлчилгээний хэлбэр					
		Урьдчилан сэргийлэх үзлэг	Амбулаторийн үзлэг, оношилгоо, эмчилгээ	Өдрийн эмчилгээ	Хэвтүүлэн эмчлэх	Хяналт тавих	Лавлагаа шаталд илгээх
Зүрх, судасны тогтолцооны өвчин /I00-I99/	Артерийн даралт ихсэх өвчин	√	√	√	√	√	√
	Зүрхний ишеми өвчин	√	√	√	√	√	√
	Зүрхний архаг/ цочмог дутагдал	√	√	√	√	√	√
	Хэрэх өвчин	√	√	√	√	√	√
	Зүрхний гажгууд	√	√		√	√	√
	Цус багадалт	√	√		√	√	
	Тархины ишемийн инфаркт	√	√	√	√	√	√
Амьсгалын тогтолцооны өвчин /J00-J99/	Гуурсан хоолойн үрэвсэл	√	√	√	√	√	
	Уушгины үрэвсэлт өвчин	√	√	√	√	√	
	Уушгины архаг бөглөрөлтөт өвчин		√	√	√	√	√
	Гуурсан хоолойн багтраа	√	√	√	√	√	
Хоол боловсруулах тогтолцооны өвчин /K00-K99/	Амны хөндийн үрэвсэлт өвчин	√	√			√	
	Шүд цоорох өвчин	√	√			√	√
	Залгиур хоолойн үрэвсэлт өвчин	√	√			√	
	Ходоодны үрэвсэлт өвчин	√	√	√	√	√	
	Гэдэсний үрэвсэлт өвчин	√	√		√	√	
	Элэгний үрэвсэлт өвчин	√	√	√	√	√	
	Элэгний хатуурал	√	√		√	√	√
	Нойр булчирхайн үрэвсэлт өвчин	√	√	√	√	√	
	Цөсний замын үрэвсэлт өвчин	√	√	√	√	√	
Арьсны өвчин /L00-L99/	Арьсны харшилт өвчин	√	√			√	√
	Нянгийн гаралтай өвчин	√	√			√	
	Вирусын гаралтай өвчин	√	√			√	
	Мөөгөнцрийн гаралтай өвчин	√	√				√
Дотоод шүүрэл ба бодисын	I хэв шинжийн чихрийн шижин	√	√			√	
	II хэв шинжийн чихрийн шижин	√	√			√	√
	Бамбай булчирхайн эмгэг	√	√			√	√

солилцооны өвчин /E00-E99/	Таргалалт	√	√			√	
Мэдрэлийн тогтолцооны өвчин /G00-G99/	Толгой өвдөлтийн хамшинж	√	√	√		√	√
	Тархины цусны эргэлтийн хямрал	√	√	√		√	√
	Цус харвалтын дараах тусламж, үйлчилгээ		√		√	√	√
	Цочмог таталт		√		√	√	√
	Эпилепси	√	√			√	√
	Тархины саажилт, нэг талын саажилт, доод мөчдийн саажилт, 4 мөчний саажилт, бусад саажилт	√	√			√	√
	Гурвалсан мэдрэлийн үрэвсэл	√	√		√	√	√
Сэтгэц, зан үйлийн эмгэг /F00-F99/	Сэтгэл гутрал	√	√			√	√
	Сэтгэл түгшил	√	√			√	√
	Нойргүйдэл	√	√		√	√	√
	Архаг ядаргаа	√	√	√	√	√	
	Тайлбарлаж боломгүй бие махбодийн зовиур шаналгаа	√	√			√	√
Донтолтын үеийн тусламж, үйлчилгээ /F00-F99/	Архинд донтох эмгэгийн үеийн тусламж, үйлчилгээ	√	√			√	√
	Тамхинд донтох эмгэгийн үеийн тусламж, үйлчилгээ	√	√			√	
	Мансууруулах болон сэтгэц нөлөөт бодист донтох эмгэгийн үеийн тусламж, үйлчилгээ	√	√			√	√
Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин /M00-M99/	Үений эмгэг, үрэвсэлт өвчнүүд	√	√	√	√	√	√
	Ясны эмгэг, үрэвсэлт өвчнүүд	√	√		√	√	√
	Булчингийн үрэвсэлт өвчнүүд	√	√		√	√	√
	Яс сийрэгжилт	√	√			√	
Шээс, бэлгийн тогтолцооны өвчин /N00-N99/	Давсагны үрэвсэл	√	√	√	√	√	
	Бөөрний тэвшинцрийн үрэвсэл	√	√	√	√	√	
	Бөөрний түүдгэнцрийн үрэвсэл	√	√		√	√	√
	Бөөр чулуужих өвчин	√	√		√	√	√
	Түрүү булчирхайн томрол	√	√			√	√
Хавдар	Элэгний	√	√			√	√
	Улаан хоолой, ходоодны	√	√			√	√
	Бүдүүн, шулуун гэдэсний	√	√			√	√

	Умайн хүзүүний /эм/	√	√			√	√
	Хөхний /эм/	√	√	√		√	√
	Түрүү булчирхайн /эр/	√	√	√		√	√
Нүд ба түүний дайврын өвчин /H00-H59/	Нүдний салстын хурц үрэвсэл	√	√			√	√
	Зовхины ба дайврын эмгэгүүд	√	√			√	√
	Нүдний битүү ба илт гэмтэл	√	√			√	√
	Торлог шилэнцрийн цус харвалт	√	√			√	√
	Нүдний түлэгдэл	√	√			√	√
	Нүдний даралтын хурц давшил	√	√			√	√
	Болор цайх	√	√			√	√
	Нярайн нүдний дайврын хурц үрэвсэл	√	√			√	√
	Гадна чихний үрэвсэл	√	√			√	√
	Дунд чихний үрэвсэл	√	√			√	√
Чих, хамар, хоолойн өвчин /H60-H95/	Гүйлсэн булчирхайн үрэвсэл	√	√		√	√	√
	Хамрын үрэвсэл		√			√	√
	Сонсгол бууралт	√	√			√	√
	Мухар олгойн үрэвсэлт өвчин		√		√		√
	Гэдэс түгжрэх өвчин		√		√		√
Зонхилон тохиолдох мэс заслын өвчний үед үзүүлэх тусламж үйлчилгээ	Хэвлийн түгээмэл үрэвсэлт өвчин		√		√		√
	Цочмог идээт үрэвсэл		√		√		√
	Уламжлалт анагаах үзлэг, оношилгоо		√	√	√	√	
	Уламжлалт анагаах ухааны тусламж /ТМА00-ТМW03/	√	√	√	√	√	
Уламжлалт анагаах ухааны тусламж /ТМА00- ТМW03/	Уламжлалт эмийн эмчилгээ		√	√	√	√	√
	Уламжлалт анагаахын засал эмчилгээ		√	√	√	√	√
	Уламжлалт анагаахын үзлэг, оношилгоо		√	√	√	√	
	Уламжлалт анагаах ухааны тусламж /ТМА00-ТМW03/	√	√	√	√	√	

2.7. Халдварт өвчний үеийн тусламж, үйлчилгээ

	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний хэлбэр				
		Урьдчилан сэргийлэх үзлэг	Амбулаторийн үзлэг, оношилгоо, эмчилгээ	Хэвтүүлэн эмчлэх	Хяналт тавих	Лавлагаа шатлалд илгээх
1.7.1	Амьсгалын замын халдварт өвчнүүд	√	√	√	√	
1.7.2	Тууралтат халдварт өвчнүүд	√	√	√	√	
1.7.3	Гэдэсний халдварт өвчнүүд	√	√	√	√	
1.7.4	Элэгний вирусын халдвар А, В, С	√	√	√	√	√
1.7.5	Сүрьеэ өвчин	√	√		√	√
1.7.6	Бэлгийн замаар дамжих халдвар	√	√		√	√
1.7.7	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчнүүд	√	√	√	√	√
1.7.8	Зоонозын шалтгаант халдварт өвчнүүд	√	√	√	√	√

2.8 Сувилахуйн тусламж, үйлчилгээ

Зорилтот бүлэг	Тусламж, үйлчилгээний жагсаалт	Тусламж, үйлчилгээний хэлбэр				
		Гэрийн эргэлт	Асаргаа, сувилгаа	Зөвлөгөө өгөх	Эрсдлийг илрүүлэх	Хянах
Жирэмсэн эмэгтэй болон төрсөн эхэд үзүүлэх сувилахуйн тусламж	Эмэгтэйн хөхийг төрөлтөд бэлтгэх	√	√	√	√	√
	Эхийн биеийн байдлыг үнэлэх	√	√	√	√	√
	Дасгал, хөдөлгөөн заах, зөвлөх	√	√	√		√
	Төрөхөд бэлтгэх	√	√	√		√
Төрсний дараах үеийн	Эхийн хөхийг арчлах	√	√	√	√	√
	Эхийн биеийн байдлыг үнэлэх	√	√	√	√	√

сувилахуйн тусламж	Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх	√	√	√	√	√
Нярайд үзүүлэх сувилахуйн тусламж	Нярайн хүй цэвэрлэх	√	√	√	√	√
	Нярайн нүд, ам, хамар цэвэрлэх, эм дусаах	√	√	√		√
	Нярайг усанд оруулах	√	√	√		√
	Нярайд иллэг хийх	√	√	√	√	√
	Нярайн жин, уртыг хэмжих	√	√	√		√
	Хөхийг зөв хөхүүлэх	√	√	√	√	√
	Өлгийдөх, өлгий бэлдэхийг зааж сургах	√	√	√		√
	БЦЖ вакцины урвал үзэх	√	√	√	√	√
Ахмад настны тусламж	Хооллолтын зөвлөгөө	√	√	√	√	√
	Дасгал хөдөлгөөн заах	√	√	√	√	√
	Сэтгэлзүйн зөвлөгөө	√	√	√	√	√
	Асран хамгаалагчид сургалт хийх	√	√	√		√
	Гэр бүлийн хүчирхийллийн зөвлөгөө	√	√	√	√	√
Хөгжлийн бэрхшээл тэй хүнд үзүүлэх тусламж	Нийгэм хамт олонд тулгуурласан сэтгэлзүйн тусламж	√	√	√	√	√
	Дасгал хөдөлгөөн заах	√	√	√	√	√
	Хооллолтын зөвлөгөө өгөх	√	√	√	√	√
	Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх	√	√	√	√	√
	Асран хамгаалагчид сургалт хийх	√	√	√	√	√
	Тоног төхөөрөмжид суурилсан тусламж	√	√	√	√	√
Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ	Эм, тарианд суурилсан тусламж					
	Хордлого тайлах	√	√	√	√	√
	Өвчин намдаах	√	√	√	√	√
	Шинж тэмдгийн	√	√	√	√	√
	Дасгал хөдөлгөөн заах	√	√	√	√	√
	Хооллолтын зөвлөгөө өгөх	√	√	√	√	√
	Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх	√	√	√	√	√
	Асран хамгаалагчид сургалт хийх	√	√	√	√	√

2.9. Зонхилон үзүүлэх гардан үйлдлийн жагсаалт

	Үйлдлийн жагсаалт	Амбулаториор	Хэвтүүлэн эмчлэх	Гэрээр
1.9.1.1	Тариа (булчин, судас тариа)	√	√	√
1.9.1.2.	Шингэн сэлбэх	√	√	√

1.9.1.3.	Цусны даралтыг үзэх	√	√	√
1.9.1.4.	Амьсгал тоолох	√	√	√
1.9.1.5.	Судасны цохилт тоолох	√	√	√
1.9.1.6.	Захын судсанд хүчилтөрөгчийн хангамж тодорхойлох	√	√	√
1.9.1.7.	Жин, өндөр үзэх, БЖИ тодорхойлох	√	√	√
1.9.1.8.	Хараа шалгах	√		
1.9.1.9	Нүд дурандах	√		
1.9.1.10	Чих дурандах	√		
1.9.1.11	Хамар дурандах	√		
1.9.1.12	Шүдний үзлэг хийх	√		
1.9.1.13	Дархлаажуулалт хийх	√		
1.9.1.14	Шарх цэвэрлэх	√	√	√
1.9.1.15	Боолт хийх	√	√	√
1.9.1.16	Жирэмсний үзлэг, хяналт	√	√	√
1.9.1.17	Жирэмсэн эмэгтэйд дасгал хөдөлгөөн заах	√	√	
1.9.1.18	Ургийн зүрхний цохилт тоолох	√	√	√
1.9.1.19	Нярайн шарлалт оношлох	√	√	√
1.9.1.20	Эмэгтэйчүүдийн үзлэг хийх	√		
1.9.1.21	Хөхний үзлэг хийх	√		
1.9.1.22	Умайн хүзүүнээс эсийн шинжилгээ (Пап сорил) авах	√		
1.9.1.23	Ерөндөг тавих, авах	√		
1.9.1.24	Хэт авиан шинжилгээ хийх	√	√	√
1.9.1.25	ЭКГ ашиглан зүрхний цахилгаан бичлэг хийх	√	√	√
1.9.1.26	Ходоод, дээд гэдэсний хаймсуур тавих	√	√	√
1.9.1.27	Шээлтүүр тавих	√	√	√
1.9.1.28	Бургуй тавих	√	√	√
1.9.1.29	Хэвтрийн өвчтөнд угаалга хийх		√	√
2.9.2. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ				
1.9.2.1	Толгой, хүзүүний бариа	√	√	√
1.9.2.2	Мөчдийн бариа буюу хэсгийн бариа	√	√	√
1.9.2.3	Бүх биеийн бариа	√	√	
1.9.2.4	Бумба тавих	√	√	√
1.9.2.5	Төөнө засал	√	√	√
1.9.2.6	Зүү эмчилгээ	√	√	√
2.9.3. Сэргээн засах тусламж, үйлчилгээ				
1.9.3.1	Физик эмчилгээ			
1.9.3.1.1	УВЧ-ээр шарлага хийх	√	√	
1.9.3.1.2	Солюкс эмчилгээ	√	√	
1.9.3.1.3	Инфра улаан туяа эмчилгээ	√	√	
1.9.3.1.4	Искра эмчилгээ	√	√	

1.9.3.1.5	Лазер эмчилгээ	√	√	
1.9.3.1.6	Электрофорез эмчилгээ	√	√	
1.9.3.1.7	Утлага хийх	√	√	√
1.9.3.1.8	Хүчилтөрөгчийн эмчилгээ	√	√	
1.9.3.1.9	Парафин эмчилгээ	√	√	
1.9.3.2	Хөдөлгөөн засал эмчилгээ	√	√	√

2.10. Оношилгоо, шинжилгээ

	Шинжилгээний нэр төрөл	Сум, тосгоны ЭМТ-д хийх	Илгээх
1.Шээсний шинжилгээ			
1.1	Туузан оношлуураар (хэмжээ, хувийн жин, рН, уураг, улаан эс, нитрит, сахар, уробилиноген, цагаан эс, кетон)	√	
1.2	Шээсний тунадаснаас наац бэлтгэж микроскопоор шинжлэх	√	
2. Цусны шинжилгээ			
2.1	Цусны бүлэг тодорхойлох	√	
2.2	Цусны хувийн тохироо үзэх (цус сэлбэх тохиолдолд)	√	√
2.3	Гемоглобин тодорхойлох	√	
2.4	Цусны ерөнхий шинжилгээ (цагаан эс, улаан эс, ялтас эс, гемоглобин, гематокрит)	√	
2.5	Улаан эсийн тунах хурд тодорхойлох	√	
2.6	Нийт лейкоцитийн тоо	√	
2.7	Гематокрит	√	
2.8	Цусны наац бэлтгэн Гемза эсвэл Эозин Гематоксинаар будаж лейкоцитыг ялгаж авах	√	
3.Биохимийн шинжилгээ			
3.1	Цусанд сахар үзэх (өглөөний өлөн цусанд тодорхойлох)	√	
3.2	Глюкозын зохих тунг өгсөнөөс хойш 1 ба 2 цагийн дараа цусны сахар тодорхойлох	√	√
3.3	Билирубин тодорхойлох	√	
3.4	Уураг тодорхойлох	√	
3.5	АПАТ тодорхойлох	√	
3.6	АСАТ тодорхойлох	√	
3.7	Креатинин (сийвэнд болон шээсэнд)	√	√
3.8	Амилаза	√	
3.9	Шүлтлэг фосфотаза (ШФ)	√	√
3.10	Гаммаглутамилтрансфераз (ГГТ)	√	√
3.11	Холестерин	√	
3.12	С урвалжит уураг	√	

4. Ийлдсийн шинжилгээ			
4.1	Тэмбүүгийн шинжилгээ (RPR, TPHA)		√
4.2	ХДХВ шинжилгээ (ФХУ)		√
4.3	HBV шинжилгээ (ФХУ)		√
4.4	HCV шинжилгээ (ФХУ)		√
5.Эмэгтэйчүүдийн сорил			
5.1	Умайн хүзүүний эсийн шинжилгээ авах (ПАП сорил)	√	√
5.2	Жирэмсэн эсэхийг тодорхойлох Хүний бета хорион гонадотропин (жирэмсний тест, түргэвчилсэн туузан оношлуур)	√	
5.3	Үтрээний арчдасын шинжилгээ	√	
6.Сүрьеэгийн шинжилгээ			
6.1	Цэрний сорьц цуглуулах, түрхэц	√	√
6.2	Өсгөврийн шинжилгээ		√
7.Хурдавчилсан оношлуур			
7.1	Тэмбүүгийн хурдавчилсан сорил	√	
7.2	ХДХВ хурдавчилсан сорил	√	
7.3	HBV хурдавчилсан сорил	√	
7.4	HCV хурдавчилсан сорил	√	
7.5	Томуугийн хурдавчилсан оношлуур	√	
7.6	Суулгалтат халдварыг илрүүлэх хурдавчилсан оношлуур	√	
7.7	Хеликобактер илрүүлэх	√	
7.8	Сахар илрүүлэх	√	
7.9	Холестрин тодорхойлох	√	
7.10	Тропонин хурдавчилсан оношлуур /шигдээс/	√	
7.11	Стафилококкийн хурдавчилсан сорил	√	
7.12	Стрептококкийн хурдавчилсан сорил	√	
7.13	Өтгөнд далд цус тодорхойлох /микроскопоор харах/	√	
7.14	Шимэгч хорхойн өндөг илрүүлэх /микроскопоор харах/	√	
8.Оношилгоо			
8.1	Зүрхний цахилгаан бичлэг	√	
8.2	Хэт авиан оношилгоо	√	
8.3	Рентген		√
8.4	Офталмоскоп	√	
8.5	Отоскоп	√	

**ГУРАВ. СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ҮЗҮҮЛЭХ БУСАД
ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ**

	Тусламж, үйлчилгээний төрөл	Чиглэл	Тухайн үед мөрдөгдөж байгаа удирдамж, заавар, стандарт, журмыг баримтална
3.1.	Хэвтүүлэн эмчлэх	Өвчний олон улсын 10 дугаар ангиллын дагуу оношийг тавина.	Оношилгоо эмчилгээний удирдамж, зааврыг мөрдөнө.
3.2.	Төрөх үеийн тусламж, үйлчилгээ	Хэвийн явцтай жирэмсний төрлөг удирдах	Жирэмсэлт, төрлөгийн хүндрэлийг удирдах заавар
		Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж	ДЭМБ-ын зөвлөмж
		Эрсдэлтэй жирэмсний төрлөг	Лавлагаа шатлалын эмнэлэгт шилжүүлэх
3.3	Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ	<i>Эрэмбэлэн ангилалт хийх</i>	Холбогдох журам, заавар
		Эрэмбэ 1 зэрэглэлд амь нас эрсдэх, амин эрхтэний үйл ажиллагаа зогсох аюул шууд заналхийлсэн, эмнэлгийн сэхээн амьдруулах хойшлуулшгүй тусламжийг 2-5 минутын дотор үзүүлж эхлэх /улаан өнгийн тэмдэг зүүнэ /	
		Эрэмбэ 2 зэрэглэлд амин эрхтэний үйл ажиллагаа ноцтой алдагдсан, цаашид амь нас эрсдэх өндөр магадлалтай үйлчлүүлэгчид эмнэлгийн яаралтай болон эрчимт эмчилгээг 10 минутын дотор үзүүлж эхлэх /шар өнгийн тэмдэг зүүнэ/	
		Эрэмбэ 3 зэрэглэлд аль нэгэн эрхтэн системийн үйл ажиллагааны ээнэгшилт алдагдаагүй, эмнэлгийн тусламжийн үйлчилгээг 30 минутаас 1 цаг хүртэл хүлээх бололцоотой /ногоон өнгийн тэмдэг зүүнэ /	
		Эрэмбэ 4 зэрэглэлд үйлчлүүлэгчийн эрхтэн системийн үйл ажиллагааны үзүүлэлтэнд архаг болон	

		ялимгүй өөрчлөлт илэрсэн, яаралтай тусламж шаардлагагүй зөвхөн эмнэлгийн үзлэг, зөвлөгөө шаардлагатай /цагаан өнгийн тэмдэг зүүнэ /	
3.4	Түргэн тусламжийн үйлчилгээ	Гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үед эмнэлгийн тусламж, үйлчилгээг <ul style="list-style-type: none"> - газар дээр нь үзүүлэх - тээвэрлэх явцад үзүүлэх - эмнэлэгт хүргэх 	

ДӨРӨВ. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ, ХАМГААЛАХ

- 4.1. Нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үндэсний хөтөлбөр,
- 4.2. Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөний эрүүл мэндийн арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлнэ.

ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНХҮҮЖИЛТЭЭР ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

- 5.1. Зарим сэргээн засах тусламж, үйлчилгээ
- 5.2. Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ
- 5.3. Өдрийн эмчилгээ, үйлчилгээ
- 5.4. Оношилгоо, шинжилгээ

		ялимгүй өөрчлөлт илэрсэн, яаралтай тусламж шаардлагагүй зөвхөн эмнэлгийн үзлэг, зөвлөгөө шаардлагатай /цагаан өнгийн тэмдэг зүүнэ /	
3.4	Түргэн тусламжийн үйлчилгээ	Гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үед эмнэлгийн тусламж, үйлчилгээг <ul style="list-style-type: none"> - газар дээр нь үзүүлэх - тээвэрлэх явцад үзүүлэх - эмнэлэгт хүргэх 	Холбогдох журам, заавар
3.5	Аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд үзүүлэх тусламж, үйлчилгээ	Хүний амь нас аврах явцад гэмтсэн, өвчилсөн иргэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх	Холбогдох журам, заавар

ДӨРӨВ. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ, ХАМГААЛАХ

- 4.1. Нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үндэсний хөтөлбөр
- 4.2. Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр, арга хэмжээ

ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНХҮҮЖИЛТЭЭР ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

- 5.1. Зарим сэргээн засах тусламж, үйлчилгээ
- 5.2. Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ
- 5.3. Өдрийн эмчилгээ, үйлчилгээ
- 5.4. Оношилгоо, шинжилгээ